



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 71

Чойр

Зорилтот бүлэгт чиглэсэн
дэд хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “а”, “ж”, 25 дугаар зүйлийн 25.1, 25.4, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.6, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь заалтууд, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 16 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Зорилтот бүлэгт чиглэсэн дэд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг улсын болон орон нутгийн хөгжлийн сангийн төсөвт тусган санхүүжүүлж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд жил бүр тайлагнаж байхыг аймгийн Засаг дарга /Г.Батсуурь/-д даалгасугай.



ДАРГА

Г.БАТЗАМ



ЗОРИЛТОТ БҮЛЭГТ ЧИГЛЭСЭН ДЭД ХӨТӨЛБӨР


Нэг. Ерөнхий мэдээлэл

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор Зорилтот бүлэгт чиглэсэн дэд хөтөлбөрийг боловсруулав.

Өнөөгийн байдал: Говьсүмбэр аймгийн суурин хүн ам 2015 оны жилийн эцсийн байдлаар 4987 өрх, 16308 хүн амтай. Нийт 4987 өрх тоологдсон нь өнгөрсөн оноос 138 өрхөөр өссөн байна. Нийт хүн амын 50.6 хувийг эрэгтэйчүүд, 49.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Нийт хүн амын 33.3 хувийг 0-15 насны хүүхэд, 61.3 хувийг хөдөлмөрийн насны буюу 16-59 насны иргэд, 5.4 хувийг өндөр настнууд эзэлж байна.

2015 оны байдлаар амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 361 өрх байна. Хүн амын хувьд авч үзвэл 1547 нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн гишүүд байгаа юм. Энэ нь нийт хүн амын 9.4 хувь буюу 100 хүн тутмын 9 нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэд байна.

Зорилтот бүлгийн иргэд /жилийн эцсийн байдлаар/



Хөгжлийн бэрхшээлтэй 669 иргэнээс эмэгтэй 293, төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 322 иргэн байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс 0-14 насны 47 хүүхэд байна. 2015 онд бүтэн өнчин 22 хүүхэд байгаа нь урьд оныхоос 5 хүүхдээр буурч, хагас өнчин хүүхэд 182 байгаа нь өнгөрсөн оныхоос 5 хүүхдээр өссөн байна.

Хөдөлмөрийн насны хүн ам 9993 байгаагаас ажил эрхлээгүй 2132 иргэн байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 460 өрх байгаа нь нийт өрхийн 9.2 хувийг эзэлж байна.

Зорилтот бүлгийн иргэдэд Нийгмийн халамжийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, бусад холбогдох хууль, дүрэм журмын дагуу тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн үйлчилгээ үзүүлэхээс бусад тэдэнд чиглэсэн сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх, нийгэм хамт олны дунд бусдын адил хөгжих боломжийг бүрдүүлэх, нийгмийн хөгжлийн үйлчилгээг үзүүлэх ажил үйлчилгээ орхигдож байна.

Иймд зорилтот бүлэгт чиглэсэн аймгийн дэд хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага урган гарч байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим:

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална. **Үүнд:**

- Хүний эрхийг дээдлэх: Хүн бүр наснаасаа үл хамааран өөрсдийн өвөрмөц хэрэгцээнд тохирсон хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох, нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын амьдралд идэвхтэй оролцох, нийгмийн баталгаагаар хангагдах эрхтэй.

- Оролцоо, хамтын ажиллагаанд түшиглэх: Зорилтот бүлгийн иргэдийн аж байдлыг дээшлүүлэх нь зөвхөн төрийн үүрэг биш бөгөөд үүнд хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, нийгэм, хамт олон чухал үүрэгтэйг харгалзан төр, иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагаа, түншлэлд тулгуурлана.

- Хэрэгцээнд суурилах: Зорилтот бүлгийн иргэд нь нас, хүйс, гэр бүлийн болон эрүүл мэндийн байдал амьжиргааны түвшин зэрэг хүчин зүйлсээс хамааран харилцан адилгүй хэрэгцээ, ашиг сонирхолтой байгааг хөтөлбөрийн үйл ажиллагаандаа харгалзаж үзнэ.

Зорилго: Орон нутгийн зорилтот бүлгийн өрхийн гишүүдийн хүсэл эрмэлзэл, эрэлт хэрэгцээ, нөөц боломж, чадавхи, идэвхи оролцоон дээр тулгуурлан боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүйн үйлчилгээг багцлан хүргэх замаар өрхийн гишүүдийг хөгжүүлэх, өрхийн амьжиргааны түвшинг нь дээшлүүлэхэд оршино.

Зорилт-1. Зорилтот бүлгийн иргэдийг нийгэм хамт олны дунд бусдын адил хөгжих, амьдралын зөв дадлыг хэвшүүлэх боломжийг бүрдүүлэх

Зорилт-2. Зорилтот бүлгийн иргэдийн амьжиргааг дэмжих

Хэрэгжүүлэх хугацаа: Зорилтот бүлэгт чиглэсэн дэд хөтөлбөрийг 2016-2020 оны хугацаанд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа

Зорилт-1 Зорилтот бүлгийн иргэдийг нийгэм хамт олны дунд бусдын адил хөгжих, амьдралын зөв дадлыг хэвшүүлэх боломжийг бүрдүүлэх

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Зорилтот бүлгийн өрхийн гишүүдийг амьдрах ухаан, амьдралын итгэл үнэмшил, амьдралын зөв зан үйлийг төлөвшүүлэх, хөдөлмөрлөх, өөрийгөө хөгжүүлэх бүтээлч ухамсарыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, лекцэнд хамруулах, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах
2. Зорилтот бүлгийн иргэдэд архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршгийн талаар мэдлэг, мэдээлэл олгох
3. Жендерийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах
4. Зорилтот бүлгийн өрхийн гишүүдэд гэр бүлийн боловсрол олгох зан үйл хандлагыг өөрчлөх арга хэмжээ зохион байгуулах
5. “Ахмадаа хүндэлье” сарын аян зохион байгуулах
6. 80-аас дээш настай ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх
7. Ахмад настнуудийг идэвхжүүлэх, бие бялдрыг нь хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлын хүрээнд ахмад настнуудын дунд соёл, спортын арга хэмжээ зохион байгуулах
8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгэм хамт олны дунд бусдын адил хөгжих боломжийг бүрдүүлэх талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн сарын аян зохион байгуулах
9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг идэвхжүүлэх, бие бялдрыг нь хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд соёл, спортын арга хэмжээ зохион байгуулах
10. Хүүхдийн эрхийг хамгаалах, тэднийг хөгжүүлэхэд чиглэгдсэн соёл урлаг, спортын уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулах
11. Өсвөр үе залуусыг хорт зуршилд автахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, лекцэнд хамруулах
12. “Хүүхдийн хүмүүжил гэр бүлээс эхтэй” эцэг, эхийн зөвлөгөөн зохион байгуулах

Зорилт-2 Зорилтот бүлгийн иргэдийн амьжиргааг дэмжих

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө”-г зорилтот бүлгийн өрхийн нөхцөл байдал, хэрэгцээ, нөөц боломж чадавхид тулгуурлан хэрэгжүүлж, өрхийн идэвхтэй оролцоог хангах
2. Орон гэргүй иргэдийн өрхийн амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулах
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг зохион байгуулах

Дөрөв. Үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт

Зорилт-1. Зорилтот бүлгийн иргэдийг нийгэм хамт олны дунд бусдын адил хөгжих, амьдралын зөв дадлыг хэвшүүлэх боломжийг бүрдүүлэх

Үр нөлөө:

1. Өрхийн гишүүдийн нийгмийн идэвх, санаачилга нэмэгдэж, олон нийтийн шинжтэй арга хэмжээнд оролцох оролцоо сайжирсан байна.
2. Өрхийн гишүүдийн сөрөг зан үйл, дадал арилж, гэр бүлийн харилцаа хандлага сайжирсан байна.
3. Сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулж хэвшсэн байна.

Зорилт-2. Зорилтот бүлгийн иргэдийн амьжиргааг дэмжих

Үр нөлөө:

1. Хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн амьжиргааны түвшин суурь үеийн түвшингээс өсч, өрхийн хөгжлийн түвшин ахисан байна.
2. Орон гэргүй иргэд өөрийн гэсэн орон гэртэй болсон байна.

Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин / 2015 /	Хүрэх түвшин			
			2017 он	2018 он	2019 он	2020 он
1	Орон нутгаас зохион байгуулж байгаа сургалт, өдөрлөг арга хэмжээнд хамрагдсан байдал	7	10	12	12	12
	- Зохион байгуулагдах арга хэмжээний тоо - Хамрагдах иргэдийн тоо	800	1100	1300	1300	1300
2	Хөгжих өрхүүдийн хөгжлийн түвшин ахисан өрхийн хувь	5%	6%	7%	8%	10%
3	Орон гэргүй өрхийн тоо	15	14	13	12	11

Тав. Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. **Үүнд:**

- 5.1.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө
- 5.1.2. Гадаад, дотоодын төсөл хөтөлбөрийн хөрөнгө
- 5.1.3. Бусад эх үүсвэр

Арав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө


10.1. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Нийгмийн бодлогын хэлтэс нь хөтөлбөрийн үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд

удирдлагаар хангах, дүн шинжилгээ хийх, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

10.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Сумдын засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулж, хагас, бүтэн жилээр үр дүнг аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнана.

10.3. Аймгийн Засаг дарга жил бүр хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийн үр дүнг Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнана.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2016 оны 7/ дугаар
тогтоолын 02 дугаар хавсралт



**ЗОРИЛТОТ БҮЛЭГТ ЧИГЛЭСЭН ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ /2016-2020/**

№	Үйл ажиллагааны чиглэл	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Санхүүжилт сая.төг /4 жилээр/	Хариуцах байгууллага
Зорилт 1. Зорилтот бүлгийн иргэдийг нийгэм хамт олны дунд бусдын адил хөгжих, амьдралын зөв дадлыг хэвшүүлэх боломжийг бүрдүүлэх							
1	Өрхийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ	Зорилтот бүлгийн өрхийн гишүүдийг амьдрах ухаан, амьдралын зөв зан үйлийг төлөвшүүлэх, хөдөлмөрлөх, өөрийгөө хөгжүүлэх, бүтээлч ухамсарыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, лекцэнд хамруулах, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах	2017-2020	Зохион байгуулсан сургалт, лекцийн тоо Хамрагдсан иргэдийн тоо	12-оос доошгүй 400-аас доошгүй	ОНХС 4.0	ХХҮГ, ГБХЗХГ, БСУГ, Сумдын ЗДТГ, холбогдох төрийн болон ТББ
		Зорилтот бүлгийн иргэдэд архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршгийн талаар мэдлэг, мэдээлэл олгох	2017-2020	Хамрагдсан иргэдийн тоо	120-оос доошгүй	ОНХС 1.0	ГБХЗХГ, ХХҮГ, Аймаг, сумдын ЗДТГ, холбогдох төрийн болон ТББ
		Жендерийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах	2017-2020	Зохион байгуулах арга хэмжээний тоо	4-өөс доошгүй	ОНХС 9.0	ГБХЗХГ, ХХҮГ, Сумдын ЗДТГ, холбогдох төрийн болон ТББ

		Зорилтот бүлгийн өрхийн гишүүдэд гэр бүлийн боловсрол олгох зан үйл хандлагыг өөрчлөх арга хэмжээ зохион байгуулах	2017-2020	Зохион байгуулах арга хэмжээний тоо	8-аас доошгүй	ОНХС 2.0	ГБХЗХГ, ХХҮГ, холбогдох төрийн болон ТББ
2	Ахмад настнуудад чиглэсэн арга хэмжээ	“Ахмадаа хүндэлье” сарын аян зохион байгуулах	2017-2020	Зохион байгуулсан аяны тоо	4-өөс доошгүй	ОНХС 6.0	ХХҮГ, Аймаг, сумдын ЗДТГ, Аймгийн ахмадын холбоо
		80-аас дээш настай ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх	2017-2020	Хамрагдсан ахмадын тоо	400-аас доошгүй	ОНХС 12.0	ХХҮГ, Аймгийн ЗДТГ, Аймгийн ахмадын холбоо
		Ахмад настнуудийг идэвхижүүлэх, бие бялдрыг нь хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлын хүрээнд ахмад настнуудын дунд соёл, спортын арга хэмжээ зохион байгуулах	2017-2020	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан ахмадын тоо	8-аас доошгүй 300-аас доошгүй	ОНХС 3.0	ХХҮГ, Аймаг, сумдын ЗДТГ, БТСГ, Аймгийн ахмадын холбоо
3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн арга хэмжээ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгэм хамт олны дунд бусдын адил хөгжих боломжийг бүрдүүлэх талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн сарын аян зохион байгуулах	2017-2020	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан иргэний тоо	8-аас доошгүй 700-аас доошгүй	ОНХС 4.0	ХХҮГ, Аймаг, сумдын ЗДТГ, Аймгийн ХБИ зөвлөл, ААНБайгууллагууд
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг идэвхижүүлэх, бие бялдрыг нь хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд соёл, спортын арга хэмжээ зохион байгуулах	2017-2020	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан иргэний тоо	8-аас доошгүй 300-аас доошгүй	ОНХС 3.0	ХХҮГ, Аймаг сумдын ЗДТГ, Аймгийн ХБИ зөвлөл, ААНБайгууллагууд
4	Өсвөр үе, хүүхдэд чиглэсэн арга	Хүүхдийн эрхийг хамгаалах, тэднийг хөгжүүлэхэд чиглэгдсэн соёл урлаг, спортын уралдаан	2017-2020	Зохион байгуулсан арга	4-өөс доошгүй 1000-аас	ОНХС 8.0	ХХҮГ,ГБХЗХГ, Аймаг, сумдын ЗДТГ,

	хэмжээ	тэмцээнүүдийг зохион байгуулах		хэмжээний тоо Хамрагдсан хүүхдийн тоо	доошгүй		ААНБайгууллагууд
		Өсвөр үе залуусыг хорт зуршилд автахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, лекцэнд хамруулах	2017-2020	Зохион байгуулсан сургалт, лекцийн тоо Хамрагдсан иргэдийн тоо	8-аас доошгүй 300-аас доошгүй	ОНХС 2.0	ХХҮГ, БСУГ, ЭМГ, СЗДТГ, Төрийн болон төрийн бус байгууллага
		"Хүүхдийн хүмүүжил гэр бүлээс эхтэй" эцэг, эхийн зөвлөгөөн зохион байгуулах	2017-2020	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн тоо	4-өөс доошгүй	ОНХС 2.0	ГБХЗХГ, ХХҮГ, Сумдын ЗДТГ, холбогдох төрийн болон ТББ
Зорилт-2. Зорилтот бүлгийн иргэдийн амьжиргааг дэмжих							
5	Зорилтот бүлгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх	"Өрхийн хөгжлийн төлөвлөгөө"-г зорилтот бүлгийн өрхийн нөхцөл байдал, хэрэгцээ, нөөц боломж чадавхид тулгуурлан хэрэгжүүлж, өрхийн идэвхитэй оролцоог хангах	2017-2020	Хамрагдсан өрхий тоо	87	ОНХС 2.0	ХХҮГ, Аймаг, сумдын ЗДТГ, ААНБайгууллагууд
		Орон гэргүй иргэдийн өрхийн амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулах	2017-2020	Гэр оронтой болсон иргэдийн тоо	4	ОНХС 12.0	ХХҮГ, Аймаг сумын ЗДТГ, ТББ
		Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг зохион байгуулах	2017-2020	Хамрагдсан иргэдийн тоо	200-аас доошгүй	ОНХС 50.0	Аймаг, сумдын ЗДТГ, ХХҮГазар
		НИЙТ				120.0	